



## МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,  
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060  
Утас: (976-11) 26 30 51, Факс: (976) 7004 3479,  
Цахим шуудан: info@energy.gov.mn

2025. 11. 18 № 6/3594  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ НАРТ

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01, 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан даалгавар, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн ээлжит хуралдааны 27 дугаар тэмдэглэлийг хүргүүлж байна.

Дээрх шийдвэрийн хэрэгжилтийг хангах үүднээс танай байгууллагын компанийн бүтцийн өөрчлөлтийн санал, тооцоо, үндэслэлийг боловсруулж, 2025 оны 11 дүгээр сарын 24-ний дотор ирүүлэхийг хүсье.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Б.ЕРЭН-ӨЛЗИЙ

170600002177

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮД, ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР, ХӨГЖЛИЙН БАНКАНД

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 27 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“6.1.ХЭЛЭЛЦСЭН нь: Бусад асуудал

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1.Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, чиг үүргийн давхардлыг арилгаж цомхон бүтэцтэй, орон тоог цөөлөх замаар төсөв хэмнэх, үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд төрийн өмчит компаниудын бүтэц, зохион байгуулалтад засаглал, ил тод байдал, комплаенсийн болон гүйцэтгэлийн үнэлгээ, дотоод аудитын хяналт хариуцсан менежерүүдийн орон тоог цомхотгож, сайн үнэлгээтэй ажилласан менежерийг ажлын байраар хангах, ажлаас чөлөөлөх асуудлыг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор шуурхай зохион байгуулахыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт болон Засгийн газрын бусад гишүүд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгав.

2.Хөгжлийн банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасныг зөрчиж, томилогдсон Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал 3.Нарантуяаг үүрэгт ажлаас нь чөлөөлж, тус банкны гүйцэтгэх удирдлагыг хуульд заасан журмын дагуу олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгон томилох ажлыг шуурхай зохион байгуулахыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Анар)-д үүрэг болгов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг, 9, 10, 11, 12, 14 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдаас ДААЛГАХ нь:

1.Иргэн төвтэй, чадварлаг, мэргэшсэн, бүтээмжтэй төрийн албыг төлөвшүүлэх, төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэх чиглэлээр:

1.1.“Цомхон, чадварлаг, бүтээмжтэй төр”-ийг төлөвшүүлэх төрийн албаны шинэтгэлийг эхлүүлж, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж өргөн мэдүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод;

1.2.төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад;

1.3.иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад;

1.4.төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад;

1.5.төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем, мэдээллийн санд дүн шинжилгээ хийж, систем хоорондын залгамж, уялдаа холбоог ханган, давхардлыг арилгах, төрөөс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй цахим үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, санал боловсруулан 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугарт;

0025800031

1.6.чадварлаг, мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэх зорилтын хүрээнд мэргэжлийн үнэлгээ буюу аттестатчилалыг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод;

1.7.Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт;

1.8.ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт.

## **2.Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учралд:**

2.1.зөвшөөрөл олгох, бүртгэх, сунгах, шат дамжлагыг 50 хувиар бууруулж, тайлан, мэдээ хүлээн авах, төлбөр, хураамж төвлөрүүлэх, зөвшөөрөл эзэмшигчид тавих явцын хяналтыг сайжруулах, хүсэлтэд 14-21 хоногийн дотор хариу өгөх, уг хугацаа өнгөрвөл зөвшөөрөл олгосонд тооцох зарчмыг хэрэгжүүлэх асуудлыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор шийдвэрлэх;

2.2.тендер шалгаруулалт явуулах стандарт, дүрэм, журам, норм, нормативын баримт бичгийг нийтэд түгээх, сурталчлах, санал авах үйл ажиллагааг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор цахим хэлбэрт шилжүүлэх;

2.3.урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож, 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

2.4.хяналт шалгалтын давхардлыг арилгаж, хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах асуудлыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор шийдвэрлэх;

2.5.хуулийн этгээдийн улсын бүртгэлийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор цахимжуулж, хялбаршуулах;

2.6.гадаадын хөрөнгө оруулагч, гадаад худалдаа эрхлэгчдэд зориулсан “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйлчилгээг И-Монгол платформын И-Бизнес хэсэгт 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор нэгтгэх;

2.7.төрийн бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор “Цахимаар түрүүнд” ("Digital first") бодлогын төслийг боловсруулан

батлуулж, төрийн байгууллагуудын цахим шилжилтийг уялдуулах ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор эхлүүлэх;

2.8.төр, хувийн хэвшлийн хамтарсан судалгаа, инновацын төслийг санхүү, татварын бодлогоор дэмжих санал боловсруулж, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

2.9.шинжлэх ухааны судалгаа, их өгөгдөл, гүн сургалт, орон зайн дүн шинжилгээнд суурилсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн системийг хөгжүүлэх;

2.10.эрдэм шинжилгээний байгууллагын бий болгосон судалгаа, хөгжүүлэлтийн үр дүн, инновацыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар эдийн засгийн эргэлтэд оруулах;

2.11.тайлан, патент, түүний эзэмшигчийн талаарх мэдээллийг нээлттэй болгож, хөрөнгө оруулагч патент, гэрчилгээ эзэмшигчтэй холбогдон хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлэх;

2.12.“Туулын хурдны зам” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж, барилга угсралтын ажлыг нийслэлийн удирдлагатай хамтран эхлүүлэх;

2.13.Улаанбаатар хотын эдийн засгийн бие даасан байдлыг хангах зорилтын хүрээнд татварын их өгөгдлийн систем нэвтрүүлэх, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг шинэчлэх хууль тогтоомжийн төслийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.

### **3.Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд:**

3.1.бүсчилсэн хөгжлийн реформ, хэрэгжүүлэх томоохон арга хэмжээний талаарх саналыг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

3.2.стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээний үйл ажиллагааг цахимжуулах ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор эхлүүлэх;

3.3.салбар бүрт мөрдөгдөх нийтлэг стандартын жагсаалтыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор боловсруулж, батлах, мөрдүүлэх арга хэмжээ авах;

3.4.лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчилж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн шинжилгээг сайжруулах ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор эхлүүлэх;

3.5.анхан шатны хоршоодын үйл ажиллагааг бэхжүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран дундын хоршоо байгуулахад нь малчдад дэмжлэг үзүүлэх, Хоршооллын үндэсний хөдөлгөөн өрнүүлэх ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор эхлүүлэх;

3.6.чөлөөт бүсүүдэд төлөвлөгдсөн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр авах арга хэмжээний санал боловсруулж 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах.

#### **4.Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад:**

4.1.худалдан авалтын гэрээ болон тендер шалгаруулалтад шалгарсан оролцогчийн талаарх мэдээллийг агуулсан цахим самбарыг хөгжүүлж 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор олон нийтэд ил тод нээлттэй болгох;

4.2.худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг сайжруулж, хууль, журамд нийцүүлэн шуурхай зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

4.3.худалдан авах ажиллагааны цахим системийн өгөгдлийн сан дахь мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны “ХҮР” системд 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор холбох;

4.4.тодорхой хугацаанд байнга худалдан авдаг чанар, стандартын шаардлага хангасан бараа, үйлчилгээг бодит үнээр худалдан авах боломжийг бүрдүүлэн Төрийн худалдан авах ажиллагааны “Цахим дэлгүүр”-т байршуулах;

4.5.гадаадын хөрөнгө оруулагч, гадаад худалдаа эрхлэгчдэд зориулсан “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйлчилгээг цахимжуулах ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор эхлүүлэх.

#### **5.Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод:**

5.1.Засгийн газрын агентлаг, бусад байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор арилгаж, бүтэц, зохион байгуулалтыг шинээр тогтоох;

5.2.төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын үр ашиг, засаглалыг сайжруулах зорилгоор бүтэц, бүрэлдэхүүнийг оновчтой тогтоох, үр ашиггүй зардлыг бууруулах, техник, технологийн шинэчлэлтийг эрчимжүүлж, бизнесийн үйл ажиллагааны ашгийг нэмэгдүүлэх, шинээр хэрэгжих төслүүдийг үр ашиг, техник, эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө, санхүүгийн тооцооллын загварчлалын дагуу үнэлэн, эрэмбэлж, төслийн компаниудыг нэгтгэх, нийлүүлэх, нээлттэй компани болгох замаар өөрчлөн байгуулах арга хэмжээг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор авч, төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын тоог бууруулах;

5.3.“Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2025-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор өргөн мэдүүлэх;

5.4.төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системийн, үйл ажиллагааг 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор эхлүүлэх;

5.5.төрийн өмчит компаниудад олон улсын стандартын дагуу эрсдэлд суурилсан дотоод аудит, хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үнэлгээ хийлгэх ажлыг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор эхлүүлэх;

5.6.Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн менежментийг салбар дундын уялдаа, зохицуулалтаар хангах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, дүнг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

5.7.Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд болон түүний үүсмэл ордыг ашиглаж байгаа хуулийн этгээдүүдтэй төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээг тогтоох хэлэлцээ хийж, дүнг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

5.8.Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд Багануурын уурхайг түшиглэн баригдах хөх нүүрсний үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, туршилт, судалгааг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор дуусган, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангуулах;

5.9.Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын “Орано Майнинг” хувьцаат компани хооронд байгуулагдсан Хөрөнгө оруулалтын гэрээнд нийцүүлэн Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, гэрээний төслийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор эцэслэн боловсруулах;

5.10.Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, бодлого санаачлах, санал өгөх боломжтой тусгай дижитал платформыг хөгжүүлэн, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор зохион байгуулах;

5.11.Газрын тухай хуульд заасны дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг боловсронгуй болгох санал боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

5.12.Багахангай өртөөнөөс Хөшигийн хөндийн “Эдийн засгийн чөлөөт бүс, үйлдвэржилт, тээвэр логистикийн бүс” хүрэх салбар төмөр замын зурвас газар, “Хөшигийн хөндий-Чойр-Замын-Үүд чиглэлийн тусгай зориулалтын авто замын зурвас газар болон Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Сэлэнгэ аймгийн Сайхан сум, Хэнтий аймгийн Борнуур суманд үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ,санал боловсруулж 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх;

5.13.төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын албан тасалгааны ашиглалтын талбайн хэмжээг нэгдсэн стандарттай болгох санал боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор танилцуулах;

5.14.газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн өгөгдөл, мэдээлэл нэгтгэх, бүрдүүлэх, түгээх, мэдээлэх үйл ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлэх, хот, тосгон, бусад суурин газрын мониторингийн сүлжээний тодорхой

байршил дахь 500 цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор зохион байгуулах;

5.15.төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг судалж, 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулах;

5.16.Засгийн газар нийгэм, эдийн засгийн томоохон асуудлаар шийдвэр гаргахын өмнө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас цахим хэлбэрээр санал авах, хэлэлцүүлэх нөхцөлийг "И-Монголиа" системд түшиглэн бүрдүүлэх;

5.17.өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн байдлаар хянаж, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах мэдээллийн нэгдсэн санг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор бий болгож, системийг хөгжүүлэх арга хэмжээ авах.

## **6.Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт:**

6.1.улс төрийн гадаад харилцааны хүрээнд хоёр хөрш болон гуравдагч хөрштэй хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцааны "тэнцвэр"-ийг хадгалах, дээд, өндөр түвшний айлчлал, арга хэмжээг хэрэгжүүлэх;

6.2.Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан, Монгол, Хятад, Орос гурван улсын төрийн тэргүүн нарын VII уулзалтын бэлтгэл зохион байгуулалтын талаар 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

6.3.иргэдийн эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас үзүүлэх тусламж, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн хүсэлтийг шийдвэрлэх хугацааг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор хоёр дахин бууруулах;

6.4.консулын үйлчилгээг цахимжуулах хүрээнд иргэдэд цахимаар үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлж, Апостиль гэрчилгээг цахимаар олгож эхлэх;

6.5.Монгол Улсын иргэдийн гадаад улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх ажлын хүрээнд 7 улстай хэлэлцээр байгуулж, "Global Passport Power Bank Ranking"-ын эрэмбийг нэмэгдүүлж, "Хүчирхэг Монгол паспорт" бодлогыг дэмжих;

6.6.дотоодын аж ахуйн нэгж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг гадаадын зах зээлд нэвтрэх боломжийг дэмжих зорилгоор олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын форум, арга хэмжээг зохион байгуулах.

## **7.Сангийн сайд Б.Жавхланд:**

7.1.нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлтийн буцаан олголт болон хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг нэмэгдүүлэх замаар татвар төлөгчдийн татварын ачааллыг бууруулж, татварын хамрагдалтыг сайжруулан далд эдийн засгийг бууруулах хуулийн төслийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

7.2.татварын хууль тогтоомжийг ойлгомжтой, тогтвортой, хөрөнгө оруулалт, бизнест ээлтэй болгох болон татвар төлөгчдийг татварын эрсдэлд орохоос урьдчилан сэргийлж, зөвлөн туслах татвар, гаалийн байгууллагын тогтолцооны шинэчлэлийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор эхлүүлэх;

7.3.татварын албанд их өгөгдлийн системийг нэвтрүүлж, тайланг автоматаар бэлтгэж хүргүүлэх, хялбаршуулсан хяналтыг зайнаас хийх, татвар төлөгчдийн эрсдэлийг автоматаар илрүүлж залруулах боломжоор хангах шинэчлэлийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор эхлүүлэх;

7.4.гаалийн мэдүүлгийг цахимжуулж, бүрдүүлэлтийг хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилан автоматаар хийх, барааны ангиллыг тодорхойлж худалдааг хөнгөвчлөх, гадаад худалдаа эрхлэгчдийг дэмжих шинэчлэлийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор эхлүүлэх;

7.5.Засгийн газраас баталсан хөрөнгийн удирдлагын бодлогын хүрээнд гадаад улсуудын төв банканд Ирээдүйн өв сангийн хөрөнгийг байршуулах хэлцлийг Монголбанктай хамтран үргэлжлүүлэх, хуримтлалыг арвижуулах;

7.6.нүүрсний экспортыг нэмэгдүүлэх чиглэлд хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах, уул уурхайн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор авч хэрэгжүүлэх;

7.7.Сэлэнгэ аймаг дахь “Алтанбулаг” авто замын боомтод 4 цахим гарц суурилуулан 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн дотор ашиглалтад оруулж, хүчин чадлыг нэмэгдүүлэх;

7.8.гадаадын зээл, тусламжийн төслүүдийг эрэмбэлэх, хэрэгжилтийг сайжруулах, ашиглалтыг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, төслийн менежментэд тогтолцооны өөрчлөлт хийж, тусгайлсан төслийн нэгжийг нэгдсэн нэгжийн зохион байгуулалтад шилжүүлэх ажлыг 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс эхлүүлэх;

7.9.валютын урсгалыг гадагшуулж буй Монгол Улсад бүртгэлгүй бараа, бүтээгдэхүүн борлуулах цахим платформуудын үйл ажиллагааг бүртгэлжүүлэх, цахим төлбөрийн баримтын системд хамруулах, гааль, татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан татвар ногдуулах, дотоодын бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийн хилээр бараа нэвтрүүлэх үйл ажилагаанд өгөгдөлд суурилсан эрсдэлийн шалгуур, арга, аргачлалыг нэвтрүүлэх замаар бизнес эрхлэх үйл ажиллагааг дэмжих ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор зохион байгуулах.

## **8.Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатарт:**

8.1.”Эрх зүйн шинэтгэл II хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

8.2.хилийн цэргийн нисэх тусгай салбарыг сэргээн байгуулж, улсын хил хамгаалалтад шилжүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанд 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор танилцуулах;

8.3.хүний эрхийг хангах хүрээнд цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журамд дүн шинжилгээ хийж, дүнг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах.

### **9.Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдиннямд:**

9.1.сүүлийн 5 жилийн хугацаанд ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олголтын байдал (аймаг тус бүрээр) болон хайгуулын ажлын үр дүнд нөөц нь бүртгэгдсэн ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээллийг бэлтгэж, 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

9.2.Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан томоохон ордуудыг стратегийн ордуудын жагсаалтад нэмэх саналыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

9.3.Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын нутагт байгуулагдах “Эрдэнэт”, Сэлэнгэ аймгийн Сайхан, Орхон сумын нутагт байгуулах “Хөтөл”, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байгуулах “Бор-Өндөр”, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байгуулах “Тавантолгой”, Ховд аймгийн Буянт, Дарви сумын нутагт байгуулах “Эко Ховд” үйлдвэрлэл, технологийн паркад тус тус үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлыг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор шийдвэрлэх;

9.4.Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Алт-3 аяныг хэрэгжүүлэх;

9.5.Геологи хайгуулын ажлыг эрчимжүүлж, хөрөнгө оруулалт шаардлагатай төрийн болон хувийн томоохон төслүүдийг “Уул уурхайн долоо хоног”, IMARC, PDAC, China Mining олон улсын арга хэмжээнүүдэд танилцуулж, сурталчлах ажлыг зохион байгуулах;

9.6.Үндэсний геологийн албанд Ашигт малтмал, газрын тосны агентлагаас холбогдох чиг үүргийг, Газар зүй, геоэкологийн хүрээлэнгээс геоэкологийн секторыг, Одон орон, геофизикийн хүрээлэнгээс геофизикийн секторыг болон Геологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, “Геологийн судалгаа, шинжилгээний төв” ТӨҮГ-ыг тус тус нэгтгэх, геологи, эрдэс баялгийн судалгааг эрчимжүүлэх цогц арга хэмжээний санал боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

9.7.газрын тосны салбарын хайгуул, олборлолтын ажлын явц, үр дүнгийн талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий хөндлөнгийн зөвлөх болон мэргэжилтнүүдийг оролцуулсан Ажлын хэсэг байгуулж, цаашид авах арга хэмжээний талаар 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

9.8.газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад хөндлөнгийн хяналт тавих үүрэг бүхий мэргэжлийн багийг ажиллуулж, үр дүнг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах.

#### **10.Батлан хамгаалахын сайд Д.Батлутаг:**

10.1.“Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги” баримт бичгийн төслийг боловсруулж 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

10.2.сумны үйлдвэрийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ашиглалтад оруулах;

10.3.Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийн шинэчлэлийн жагсаалтыг 2025 оны 08 дугаар сарын 30-ны дотор баталж, хэрэгжилтийг эрчимжүүлэх;

10.4.Батлан хамгаалахын аж үйлдвэрлэлийг эрчимжүүлж, нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дроныг дотоодод үйлдвэрлэж угсрах.

#### **11.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатарт:**

11.1.уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, түүнд дасан зохицох, даван туулах чадавх бэхжүүлэх Үндэсний зорилтыг шинэчлэн боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

11.2.Улаанбаатар хот болон томоохон суурин газруудын агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

11.3.байгаль орчны хяналтын чиглэлээр ашиглаж байгаа 11 төрлийн хяналтын хуудсыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор цахимжуулж, агаар, хөрс, усны бохирдол, хог хаягдал зэрэг хүрээлэн буй орчны бохирдлын олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн цахим системийг боловсронгуй болгох, хэрэглээнд нэвтрүүлэх;

11.4.уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн болон хэтийн төлөвийг олон загвараар нарийвчлан гаргах, цаг агаарын урт хугацааны урьдчилсан мэдээг тооцоолох чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор өндөр хурдны суперкомпьютерийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ажиллуулж эхлэх;

11.5.байгаль орчинд ээлтэй, хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулж, барилга угсралтын ажлыг нийслэлийн удирдлагатай хамтран эхлүүлэх.

#### **12.Боловсролын сайд П.Наранбаярт:**

12.1.хүний хөгжил, ур чадварын түвшинг ахиулах зорилгоор сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн

хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг судалж, саналаа 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

12.2.боловсролыг дэмжих жилийн хүрээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны цалин, хөлсийг нэмэгдүүлэх, орон сууцны дэмжлэг үзүүлэх санал боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

12.3. 2025-2026 оны хичээлийн жилд бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад дутагдалтай байгаа багшийн орон тоог нөхөж, цэцэрлэг, сургуулийн хамран сургалтын түвшинг өмнөх хичээлийн жилээс ахиулах, сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажлын бэлтгэлийг 2025 оны 08 дугаар сарын 30-ны дотор бүрэн хангах;

12.4.хүний нөөц, ажиллах хүчний чадавхийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ажлын хажуугаар мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын хөтөлбөрт суралцах, суралцангаа ажиллах боломж олгох хөтөлбөр боловсруулж 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

12.5.гэр бүл, нийгмийн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд зориулсан эрүүл, аюулгүй орчинд амьдрах, боловсрол эзэмших, нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх цогц арга хэмжээний саналыг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

12.6.шинжлэх ухаан, технологи, эрүүл мэндийн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах арга хэмжээг эхлүүлэх.

### **13.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакирт:**

13.1.Капитал, Чингис хаан банкуудад байршуулаад авч чадаагүй нийгмийн даатгалын сангийн чөлөөт хөрөнгийг эргүүлж авах талаар хуулийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хэрэгжилтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

13.2.нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтыг олон нийтэд ил тод, шилэн болгох арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор авах;

13.3.гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ёс суртахуун, хариуцлагын боловсролыг дээшлүүлэх, гэрч, хохирогчийг хамгаалах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр авах цогц арга хэмжээний төлөвлөгөөний төслийг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

13.4.хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүчирхийлэл, осол, гэмтлийг бууруулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

13.5.“Халамжаас хөдөлмөрт”, “Хамгийн сайн халамж бол хөдөлмөр эрхлэлт” бодлогын хүрээнд зорилтот бүлэгт чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээ үзүүлэх төрөлжсөн төвийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор байгуулах;

13.6.нас барсан даатгуулагчийн ар гэрт нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх саналыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэх;

13.7.хөгжлийн тэргүүлэх салбарын эрэлтэд суурилсан хүний нөөцийг бэлтгэх зорилтот сургалт, хөтөлбөрийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор боловсруулж, хэрэгжүүлэх;

13.8.залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хувийн хэвшилд дадлага хийх, төрөөс хувийн хэвшил рүү шилжихийг дэмжих тусгай хөтөлбөрийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор боловсруулж, хэрэгжүүлэх.

#### **14.Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд:**

14.1.далайн хамгийн ойр боомтуудтай холбогдох Монгол, Орос, Хятад гурван улсыг холбосон Эрэнцав-Бичигт чиглэлийн Зүүн босоо төмөр замыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барьж байгуулах ажлыг эрчимжүүлэх;

14.2.Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хэвийн, тасралтгүй үргэлжүүлэхэд онцгойлон анхаарч, цаашид Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч, Ханги-Мандал боомтуудыг төмөр замаар холбох асуудлаар хятадын талтай хийх яриа, хэлэлцээг “Эрдэс баялаг, эрчим хүч дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын хамтарсан зөвлөл”-өөр дамжуулан эрчимжүүлэх;

14.3.Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх 56.9 км хатуу хучилттай авто замын ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ашиглалтад оруулах;

14.4.“Монголын төмөр зам” ТӨХК, Чайна энерги компани хооронд байгуулсан нүүрс тээвэрлэлтийн гэрээний дагуу Гашуунсухайт-Ганцмод боомтод зориулсан шинэ гарц байгуулах, 1.0 сая.тн ачаа тээвэрлэх ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор эхлүүлэх;

14.5.олон улсын нислэгийн чиглэл, давтамжийн тоо өсч, зорчигч, жуулчдын урсгал жил бүр нэмэгдэж байгаагаас шалтгаалан үүссэн “Чингис хаан” Олон улсын нисэх онгоцны буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагыг харгалзан тус нисэх буудлыг өргөтгөх судалгаа, тооцоог 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор бэлэн болгох;

14.6.зам, тээврийн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах арга хэмжээний санал, шийдвэрийн төслийг 2025 оны 08 дугаар сарын 25-ны дотор Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх;

14.7.Багахангай-Хөшигийн хөндийн салбар төмөр замыг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн дотор багтаан ашиглалтад оруулах;

14.8.замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах зорилгоор “Нэгдүгээр тойрог зам” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, барилга угсралтын бэлтгэл хангах ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулах;

14.9.Улаанбаатар хотод хэрэгжүүлэх их багтаамжийн нийтийн тээврийн Метро төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг эцэслэн шийдвэрлэх саналыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах.

#### **15.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрамд:**

15.1.“Соёлын орон зай бидний орчин бүтээлч аян”-ыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор зохион байгуулах;

15.2.хувь хүний соёл, ёс зүй, эерэг хандлага, эелдэг харилцааг эрхэмлэхэд чиглэсэн “Эерэг хандлага-идэвхтэй залуучууд” нийгмийн нөлөөллийн аяныг олимп, тив дэлхийн медальт тамирчидтай хамтран 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хэрэгжүүлэх;

15.3.“Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэл тогтоох” журам”-ын төслийг боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

15.4.“Хүн амын бие бялдрын сорилын шалгуур үзүүлэлт, түвшнийг тогтоох, үр дүнг тооцох үйл ажиллагааны журам”-ын төслийг боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

15.5.улсын зэрэглэлтэй аялал жуулчлалын бүсүүдийг тогтоож, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх үзэл баримтлалын хүрээнд урьдчилсан төлөвлөлтийг боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.

#### **16.Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгаланд:**

16.1.шинэ суурьшил болон хот, суурин газрын дахин төлөвлөлтийн бүсэд төлөвлөгдсөн орон сууцны хотхон, хорооллын төслийг төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжийг бий болгох зорилгоор хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлж, үр дүнг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

16.2.иргэдийг орон сууцжуулах, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжихэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх, ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх, зээлийг зорилтот бүлэгт түлхүү олгодог болгох зорилгоор "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-д өөрчлөлт оруулах асуудлыг судалж, саналаа 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

16.3.дулааны алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих зорилгоор барилгын материалын нэмэгдсэн өртгийн албан татварыг нэг жилийн

хугацаанд хөнгөлөх асуудлыг судалж, саналаа 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

16.4.улсын хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй “Ногоон нуур 1008 айл”, “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэн барих /Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймаг”, “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих”, “Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх”, “Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах” төслүүдийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ашиглалтад оруулах;

16.5.хүн амыг ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар тэгш хангах, хүртээмжийн ялгааг бууруулах зорилгоор улсын хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах санал боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

16.6.барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зөвшөөрлийн нэгдсэн систем буюу “License.mn”-д шилжүүлэх, зөвшөөрөл олгох явцыг И-Монгол системээр мэдээлэх, зөвшөөрөл олгох хугацааг хүсэлт гаргаснаас хойш 1-3 хоногт шийдвэрлэх боломжийг бүрдүүлж, 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ашиглалтад оруулах;

16.7.барилгын салбарын импортын хараат байдлыг бууруулж, валютын урсгалыг дотооддоо үлдээх, ажлын байрыг нэмэгдүүлэх, барилгын материалын үйлдвэрлэл, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, аймаг, нийслэлийн барилгын материалын сорилт, шинжилгээний лабораториудын бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчныг шинэчилж, төвлөрсөн удирдлагатай, давхардалгүй тогтолцоонд шилжүүлэх зорилгоор “Барилгын материалын үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийг боловсруулж 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

16.8.эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцыг шинээр барих болон одоо байгаа амины орон сууцаа эрчим хүчний хэмнэлттэй болгон шинэчлэн яндангаа буулгах өрхөд ипотекийн хөнгөлөлттэй зээл олгох, Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан барьцаа хөрөнгийн баталгаа гаргах эрх зүйн боломжийг судалж, саналаа 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

16.9.хотын гол гудамжны дагуу явган хүний замаас тусгаарлагдсан дугуйн замыг нэмэгдүүлэх, тэмдэг, тэмдэглэгээ, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор гүйцэтгэх;

16.10.төв суурин газрын орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны өвөлжилтийн бэлэн байдлыг хангуулж, үр дүнг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

16.11.иргэдийн орон сууц худалдан авах хуримтлалыг дэмжих, олон нийтийн оролцоонд суурилсан санхүүгийн схемийг нэвтрүүлэх, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын сангуудыг татан оролцуулах замаар санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлж, ипотекийн

банкны чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Үндэсний орон сууцжуулалтын санхүүгийн корпорацийг байгуулах эрх зүйн орчныг судалж, 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

16.12.агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд 5,000 өрхийг 2025-2026 онд хийн түлшинд шилжүүлэх ажлыг нийслэлийн удирдлагатай хамтран зохион байгуулах.

### **17.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт:**

17.1.хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн оновчтой төлөвлөх, хөрөнгө оруулалтыг зөв зохистой зарцуулах, паркт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх талаар нэгдсэн бодлого боловсруулж, 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

17.2.“Цагаан алт”, “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд олгож байгаа дэмжлэгийг малчдын хоршоо, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжихэд чиглүүлэх “Хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр” боловсруулж, бүс нутгийн онцлогийг харгалзан ялгавартай байдлаар хэрэгжүүлэх, зээлийг тасралтгүй олгох чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран бодлогын шийдвэр боловсруулж, хэрэгжүүлэх;

17.3.хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах арга хэмжээний санал, шийдвэрийн төслийг 2025 оны 08 дугаар сарын 25-ны дотор Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх;

17.4.”Улсын аварга малчин, Улсын хошой аварга малчин, Улсын аварга саальчин, Улсын аварга фермер, Улсын аварга тариаланч хамт олон, Улсын аварга тариаланч шалгаруулах журам”-ыг бүсчилсэн хөгжлийн бодлого, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн онцлогт нийцүүлэн боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

17.5.Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд 7 аймгийн 9 суманд 2,970 га талбайг услах хүчин чадал бүхий 9 услалтын системийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ашиглалтад оруулах;

17.6.отрын бүсийг “эрүүл бүс” болгох зорилтын хүрээнд аймаг дундын 9 отрын бүсэд “Малын эрүүл мэндийн нэгдсэн төв” байгуулах, бүс тус бүрд ариутгалын автомашин (ДУК) олгох, сэг зэм устгах талбай байгуулах ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор зохион байгуулах;

17.7.малын гаралтай түүхий эдийг боловсруулах, ажлын байр нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортод гаргах хүчин чадал бүхий дэлхийн жишигт нийцсэн хөдөө аж ахуйн “Эмээлт эко” аж үйлдвэрийн паркийн инженерийн шугам сүлжээ, эх үүсвэрүүдийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх.

## **18.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугарт:**

18.1.нийгэм, эдийн засгийн салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновацын дэвшилтэт шийдлийг нэвтрүүлэх, инновац, хиймэл оюуныг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд болон гарааны компанид дэмжлэг үзүүлэх, олон улсын зах зээлд гарч, өрсөлдөх боломжийг бүрдүүлэх арга хэмжээний саналыг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

18.2.төрийн байгууллагын мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим шилжилтийг бүх шатны төрийн байгууллагад хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг хэмжих, ил тод тайлагнах арга хэмжээний талаар 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

18.3.төрийн цахим үйлчилгээний стандарт, журмыг боловсронгуй болгох талаарх саналыг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

18.4.гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэнийг танин баталгаажуулах хялбар нэвтрэлтийн боломжийг бүрдүүлсэн найдвартай баталгаажуулалт бүхий “Үндэсний танилт нэвтрэлтийн Дан 2.0 систем”-ийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор нэвтрүүлэх;

18.5.хиймэл оюунд суурилсан виртуал оператор бүхий Төрийн үйлчилгээний нэгдсэн систем И-Монгол 5.0 шинэчлэгдсэн хувилбарыг 2025 оны 09 дүгээр 20-ны өдрийн дотор ашиглалтад оруулах;

18.6.төрийн байгууллагын албан бичгийг иргэд цахимаар, эсхүл цаасаар хүлээн авах боломж, сонголтыг бий болгох;

18.7.их өгөгдөл, хиймэл оюун ухааны үндэсний стратеги боловсруулж, хэрэгжүүлэх аргачлалын талаар 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

18.8.бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор хуулийн этгээд байгуулах, бүртгүүлэх бүхий л үйл ажиллагааг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Bussiness”-т, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зөвшөөрлийн цахим систем “license.mn”-д тус тус нэгтгэх ажлыг зохион байгуулах.

## **19.Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнд:**

19.1.“Хаалганаас хаалганд” зарчмаар нөхөн дархлаажуулах ажлыг эрчимжүүлж, Улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалтыг улсын хэмжээнд 95 хувьд хүргэх ажлыг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор зохион байгуулж дуусгах;

19.2.хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор эхлүүлэх;

19.3.эрүүл мэндийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаарх саналыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

19.4.элэг шилжүүлэн суулгах дурангийн мэс заслыг Монгол Улсад нутагшуулах ажлыг эхлүүлэх;

19.5.даатгуулагчийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх (E-daatgal), даатгуулагчидтай харилцах, эрүүл мэндийн даатгалын мэдээллийг хүртээмжтэй хүргэх зорилгоор хиймэл оюун ухаанд суурилсан харилцах агент (chatbot) нэвтрүүлэх;

19.6.Геронтологийн үндэсний төвийн барилгыг ашиглалтад оруулах;

19.7.Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн "Хүүхдийн зөвлөх поликлиник"-ийн өргөтгөлийн барилгыг шуурхай ашиглалтад оруулах асуудлыг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

19.8."Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяа "Эрдэнэт медипас эмнэлэг" хязгаарлагдмал хариуцлагатай компанийг "Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв" эмнэлэг болгон өөрчлөн зохион байгуулж Эрүүл мэндийн яамны харьяанд шилжүүлэх асуудлыг 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

## **20.Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэнд:**

20.1.дулааны цахилгаан станцуудын аюулгүй байдлыг хангах зорилгоор хяналтын мэдээллийн систем суурилуулах асуудлыг судалж, саналаа 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

20.2.эрчим хүчний салбарт үндэсний мэргэжилтэн бэлтгэх дотоодын их, дээд сургуулиудын санхүүгийн болон багшлах боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх асуудлаар санал боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

20.3."Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-д болсон ослын улмаас үүссэн дулааны үйлдвэрлэлийн дутагдлыг нөхөх техникийн шийдлийг гаргаж, осолд өртсөн барилга байгууламжийг сэргээх ажлыг зохион байгуулах;

20.4.Говь-Алтай аймгийн Есөнбулаг дэд станцад 10 МВт-ын хүчин чадалтай 42 МВт/ц-ийн багтаамжтай батарей хуримтлуурын станцыг 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ашиглалтад оруулах;

20.5.Тосон дулааны цахилгаан станцын эхний ээлжийг байнгын ашиглалтад хүлээн авах ажлыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулах;

20.6."Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих" төслийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, явц, үр дүнг 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

20.7.цахилгаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөх шинэчлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийн тооцоог хийж, 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

20.8.дулааны шугамын засвар, үйлчилгээг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор дуусгах;

20.9.Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 150 МВт-ын хүчин чадалтай 2 дахь хэсгийн барилга угсралтын ажлыг эрчимжүүлж, 2025 онд багтаан ашиглалтад оруулах;

20.10.хотын эрчим хүчний өсөн нэмэгдэх хэрэгцээг найдвартай эх үүсвэрээр хангах зорилгоор Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт 340 Гкал дулаан, 300 МВт цахилгаан үйлдвэрлэх хүчин чадалтай "ТЭЦ-5" дулааны цахилгаан станцыг барьж, ашиглалтад оруулах ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран эхлүүлэх.

21.Энэ албан даалгаврын хавсралтад заасан хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов.

22.Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг сар бүрийн сүүлийн 7 хоногийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод даалгав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Ерөнхий сайдын  
2025 оны .07 дугаар сарын 03-ны  
өдрийн .04 дүгээр албан даалгаврын  
хавсралт

ЗАСГИЙН ГАЗРААС ЯАРАЛТАЙ САНААЧЛАН БОЛОВСРУУЛЖ, ӨРГӨН  
МЭДҮҮЛЭХ, БАТЛУУЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ

| № | Арга хэмжээ                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | Хариуцагч                                                                    |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------|
| 1 | Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                            | Монгол Улсын Шадар сайд (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн), |
| 2 | Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон Нийтийн өмчийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулах                                                                                                                                                                                                                                                        | ЗГХЭГ                                                                        |
| 3 | Цомхон, чадварлаг, бүтээмжтэй төрийг төлөвшүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                    | ЗГХЭГ                                                                        |
| 4 | Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн газар зүйн нэрүүдийг монгол хэл дээр зөв нэрээр нь баталгаажуулж, хойч үедээ газар зүйн үнэн, зөв нэрийг өвлүүлэн үлдээх, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах зорилгоор "Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах Газар зүйн нэрийг батлах, хүчингүй болгох тухай" УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх | ЗГХЭГ                                                                        |
| 5 | Газрын сан нэгдмэл байх, газар төрийн хяналт, хамгаалалтад байх зарчмын хүрээнд Газрын тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                   | ЗГХЭГ                                                                        |
| 6 | Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын байр зүйн зургаар бүрэн хангах, газрын нэгдмэл санг бүртгэлжүүлэх, хаяг, хаягийн өгөгдлийг олон улсын жишиг болон өөрийн орны практик шаардлагад нийцүүлж, хаягжуулах зорилгоор Геодези, зураг зүйн тухай хууль Хаягжуулалтын тухай хууль болон Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх | ЗГХЭГ                                                                        |
| 7 | Орон нутгийн чиг үүргийн онцлогийг харгалзан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын                                                                                                                                                                                                                                                                     | ЗГХЭГ, ЭЗХЯ, СЯ, АҮЭБЯ                                                       |

| №  | Арга хэмжээ                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | Хариуцагч      |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|
|    | албан татварын тухай, Газрын тухай хууль, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                            |                |
| 8  | Шинжлэх ухааны паркийг төрийн, хувийн болон төр-хувийн хэвшлийн хамтарсан хэлбэрээр байгуулах эрх зүйн үндсийг тогтоох, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, төрийн дэмжлэг, санхүүжилт, хяналтын тогтолцоог тодорхойлж, шинжлэх ухааны паркийн үйл ажиллагааг цогц байдлаар зохицуулах зорилгоор Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                         | ЭЗХЯ           |
| 9  | Монгол Улс болон Евразийн Эдийн Засгийн Холбоо (ЕАЭЗХ), түүний гишүүн орнууд хоорондын Худалдааны түр хэлэлцээрийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулах                                                                                                                                                                                                                                                                                                                                      | ЭЗХЯ           |
| 10 | Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг гадаадын шууд хөрөнгө оруулалтад түшиглэн дэмжих, Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, урамшуулахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                           | ЭЗХЯ           |
| 11 | Нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, эрсдэлийн оновчтой удирдлагад суурилан төр, хувийн хэвшил урт хугацаанд үр ашигтай хамтран ажиллах болон санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх | ЭЗХЯ           |
| 12 | Баялаг бүтээгчдийг дэмжих багц хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | ЭЗХЯ<br>ХЗДХЯ  |
| 13 | Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх, гэрч, хохирогчийг хамгаалах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                       | ЭЗХЯ<br>ГХЯ    |
| 14 | Худалдаа, эдийн засгийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Худалдааны тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | ЭЗХЯ<br>ГХЯ    |
| 15 | Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох, нөлөөлөл, эрсдэл, эмзэг байдал, гарз хохирол, хүлэмжийн хийн болон экосистемийн тэнцвэр, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахтай холбоотой харилцааны зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Уур амьсгалын                                                                                                                                                                                           | ЭЗХЯ<br>БОУАӨЯ |

| №  | Арга хэмжээ                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | Хариуцагч |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
|    | өөрчлөлтийг даван туулах тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |           |
| 16 | Бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын шаталсан тогтолцоог боловсронгуй болгох, татварын шударга, зайлшгүй байдлыг бэхжүүлэх, татварын өр хураах, хөрөнгө битүүмжлэх үйл ажиллагааг татвар төлөгчийн үйл ажиллагааны эрсдэлийн түвшнээс хамаарч уян хатан зохицуулан, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих, зөвлөн туслах чиглэлээр татварын багц хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх                                          | СЯ        |
| 17 | Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг оновчтой хуваарилах, чиглүүлэх, хөрөнгө оруулалтын төслүүдийг ангилах, түүнд хамаарах зохицуулалтыг бий болгох, төслүүдийн бэлтгэл ажил болох техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн шаардлагыг тодорхой болгох, төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, өмчийн удирдлага, ашиглалтын үйл ажиллагааны зохицуулалт бүхий Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх | СЯ        |
| 18 | ЮНЕСКО-ийн 2001 оны “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг 2025 оны 9 дүгээр сард багтаан өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                           | СЯ        |
| 19 | Эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                       | ХЗДХЯ     |
| 20 | Гэр бүл, хүүхдийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | ХЗДХЯ     |
| 21 | Ашигт малтмалын хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                   | АҮЭБЯ     |
| 22 | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | АҮЭБЯ     |
| 23 | Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нислэгийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, улсын нисэхийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага, хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                      | БХЯ       |
| 24 | Амьтны тухай хууль, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                    | БОУАӨЯ    |

| №  | Арга хэмжээ                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | Хариуцагч |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| 25 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | ГБХНХЯ    |
| 26 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | ГБХНХЯ    |
| 27 | Амьжиргааны түвшин доогуур, эмзэг байдалд өртсөн өрх, иргэний амьжиргааг дэмжих, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, бие даан амьдрах чадавхыг нэмэгдүүлэх, эх, хүүхдэд чиглэсэн үйлчилгээг халамжийн бодлогоос зааглах, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах замаар амьжиргааг нь дэмжиж, халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх зорилгоор Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | ГБХНХЯ    |
| 28 | Монгол Улсад хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох, иргэдийн эрх ашгийг хамгаалах, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ирээдүйд иргэд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах, тэтгэврийн хэмжээ нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлэх, тэтгэврийн хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжих, бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгох, тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжих, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулах, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг хийх зорилгоор Нийгмийн даатгалын багц хууль (Хувийн нэмэлт тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай)-ийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх | ГБХНХЯ    |
| 29 | Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | ГБХНХЯ    |
| 30 | Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | ГБХНХЯ    |
| 31 | Иргэдийг орон сууцжуулах, тэр дундаа бага, дунд орлоготой болон зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | ХББОСЯ    |



САЙД НАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.07.02 № ХЭГ/1849  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Албан даалгавар  
хүргүүлэх тухай

“Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврыг Танд хүргүүлж байна.

Албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, үр дүнгийн талаарх мэдээллийг сар бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг хүсье.

Хавсралт 02 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000255008745

Хянасан: Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул  
Боловсруулсан: Хууль, эрх зүйн газрын референт Б.Төрбат  
Хувь: 2





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг мөрдөж, төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг өндөржүүлэн, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын гишүүдэд ДААЛГАХ нь:

1.Засгийн газрын үйл ажиллагаа шуурхай, тасралтгүй, тогтвортой байх зарчмыг хангаж ажиллах хүрээнд:

1.1.шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж, ард иргэдээ сонсон, итгэл, хүлээлт, шаардлагад нь нийцэж ажиллах;

1.2.төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах;

1.3.яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх;

1.4.салбарын хэмжээнд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган, цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбарын онцлогт нийцсэн инновац, шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглах;

1.5.улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах бодитой ажлыг зохион байгуулан, тодорхой ахиц гаргаж, үр дүнг тайлагнах;

1.6.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

1.7.салбарын хэмжээнд нэн тулгамдсан, шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай асуудлыг Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд тусгуулан, шуурхай шийдвэрлэх;

0025800022

1.8.Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрдөж, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдтэй нягт уялдаатай ажиллах, хүндэтгэлтэй хандах.

## 2.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:

2.1.Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, зөрчсөн үйлдэл гаргахгүй байх;

2.2.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох;

2.4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх;

2.5.төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх;

2.6.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах.

## 3.Засгийн газрын хуралдааны дэг, зохион байгуулалтыг хангах чиглэлээр:

3.1.хуралдааны дэгийг чанд мөрдөж, зөрчихгүй байх;

3.2.Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох;

3.3.Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн, танилцуулсан, эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлыг бүрэн хариуцаж, гарсан шийдвэр, үр дүнгийн талаар олон нийтэд үнэн зөв, бодитой мэдээлэл өгч байх.

4.Энэ албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг сар бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд, биелэлтэд нь хяналт тавьж, явц, үр дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР